

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ ХОРИНЗУРГАДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны есдүгээр сарын 08-ны 14 цаг 11 минутад эхэлж, 15 цаг 12 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 01 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Үндэсний хөгжлийн газар, Төрийн өмчийн хороо, бодлого зохицуулалтын газар, Татварын ерөнхий газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Биеийн тамир, спортын газар, Иргэний нисэхийн ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар зэрэг арван агентлагийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбатын 2016 оны 9 дүгээр сарын 107-ны өдрийн ХЭГ/1478 тоот албан бичгээр Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Үндэсний хөгжлийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Татварын ерөнхий газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Биеийн тамир, спортын газар, Иргэний нисэхийн ерөнхий газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар зэрэг арван агентлагийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалга ирүүлснийг хэлэлцээд, 2016 оны 9 дүгээр сарын 08-наас Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2016 оны 10 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.
2	Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ц.Сандуйн 2016 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 1/372 тоот албан бичгээр иоүүлсэн захиалгыг хэлэлцээд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн

		даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалтын зарыг 2016 оны 9 дүгээр сарын 08-наас Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй мэдээлж, сонгон шалгаруулалтыг 2016 оны 10 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.
3	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдын 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн 01/2901 тоот албан бичгээр ирүүлсэн захиалгыг хэлэлцээд, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалтын зарыг 2016 оны 9 дүгээр сарын 08-наас Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй мэдээлж, сонгон шалгаруулалтыг 2016 оны 10 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.
4	Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдын 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн 01/2901 тоот албан бичгээр ирүүлсэн захиалгыг хэлэлцээд, Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд нийслэлийн Захирагчийн Ажлын албаны даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалтын зарыг 2016 оны 9 дүгээр сарын 08-наас Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй мэдээлж, сонгон шалгаруулалтыг 2016 оны 10 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.
5	Ховд, Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын	Ховд, Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны

	байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлуулахаар ирүүлсэн захиалгыг хэлэлцээд, сонгон шалгаруулалтын зарыг 2016 оны 9 дүгээр сарын 08-наас Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй мэдээлж, сонгон шалгаруулалтыг 2016 оны 10 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.
6	Шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх үүднээс Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “в”-д заасныг баримталж, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссын НСШ/14 дүгээр дүгнэлтийг тус тус үндэслэн, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаас:</p> <p>Тэгшжаргалын Эрдэнэчимэгийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА